

3-БГАУ-1 БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

Маягт 3-БГАУ-1-ийг мал, амьтны гоц халдварт өвчний тохиолдлын талаарх мэдээллийг бүрдүүлэхэд ашиглана.

БҮЛЭГ I: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Өвчний голомтын бүс: “голомтын бүс” гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг хэлнэ. /“Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 4.1.11-т зааснаар/

1.1. Аймаг, нийслэл: Тухайн өвчин гарсан аймаг, нийслэлийн нэрийг гаргацтай бичиж, кодыг бичнэ. "аймаг, нийслэлийн код"-ийг Монгол улсын засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 69 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын бүсчлэлийн кодыг ашиглан бичнэ. Жишээ нь: Архангай аймаг 65000, Хөвсгөл аймаг 67000 Хамарсан тоо Тухайн өвчлөл хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ.

1.2. Сум, дүүрэг: Тухайн өвчин гарсан сум, дүүргийн нэрийг гаргацтай бичиж, холбогдох кодыг бичнэ. "сум, дүүргийн код"-ийг Монгол Улсын бүсчлэлийн кодыг бичнэ. Жишээ нь: Архангай аймгийн Хашаат сум 65010, Хөвсгөл аймгийн Мөрөн сум 67120 Хамарсан тоо Тухайн өвчлөл хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ.

1.3. Баг, хороо: Өвчний голомт гарсан баг, хороо, газрын нэрийг гаргацтай бичиж, холбогдох кодыг маягтын зааварт тусгагдсан баг, хорооны кодыг тэмдэглэнэ. Хамарсан тоо Тухайн өвчлөл хэдэн баг, хорооны нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ.

1.4. Хаяг: Тухайн өвчин гарсан газрын хаягийг гаргацтай, дэлгэрэнгүй бичнэ.

1.5. Гурван үгт хаяг: Ухаалаг гар утасны what3words программыг ашиглан авсан байршлын 3 үгийг бичнэ. Жишээлбэл: жаалхүү.уриалах.аврагч гэх мэт. Координат нь тодорхой бол бичихгүй байж болно.

1.6. Голомтын солбицол: голомтын байршлын уртраг, өргөргийг градус, минут, секундээр илэрхийлэн бичнэ. Жишээ нь: $48^{\circ}50'50.06''$, $106^{\circ}50'59.8''$

БҮЛЭГ II: НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2. Өвчний нэр: Тухайн мал, амьтны гоц халдварт өвчний нэрийг гаргацтай бичнэ.

3. Хүнд халдах эсэх: Тухайн өвчлөл нь хүнд халдах эсэхийг тийм, үгүй гэх байдлаар сонгож чагтална.

4. Нөхцөл байдлын зураг: тухайн нөхцөлд байдлын байршил, хамарсан цар хүрээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, байр зүйн зураг болон гамшгийн орон зайн мэдээллийн системд зураглаж тус маягтад хавсаргана. хавсаргаагүй тохиолдолд тайлбарыг бичнэ. Нөхцөл байдлын зурагт хүснэгт 2, 5, 7, 9-д заасан мэдээллийг тэмдэглэнэ.

5. Хугацаа

Тухайн өвчин гарсан, хорио цээрийн болон хязгаарлалтын, дэглэм тогтоосон, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм цуцалсан он, сар, өдрийг дарааллын дагуу бүрэн гүйцэд, гаргацтай бичнэ.

6. Малын өвчин гарсан шалтгаан

Малын өвчин гарсан шалтгааны урьдчилсан таамгийг эхний буюу 1 дүгээр баганад, шалтгаан тогтоогдсон үед батлагдсан буюу 2 дугаар баганад аль тохирохыг дугуйлна.

7. Өвчилсөн малын мэдээлэл*

Нийт өвчилсөн, тусгаарласан, хорогдсон, устгасан, эдгэрсэн, вакцинжуулсан малыг төрлөөр ялган нийт тоог бичнэ.

*Тайлбар: * тэмдэг бүхий мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагаас баталгаажуулан авна.*

8. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон тухай мэдээлэл

Мэргэжлийн багийн гишүүдийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар тогтоосон бүс тус бүрд хамрагдсан малчин өрх, хүн ам тоо болон мал, амьтныг төрлөөр ялган харгалзах баганыг бөглөнө.

9. Ажилласан хүч хэрэгсэл

Мал, амьтны гоц халдварт өвчний хор уршгийг арилгахад ажилласан хүч хэрэгслийн мэдээллийг бүртгэнэ.

1, 2 дугаар мөрөнд: Мал, амьтны гоц халдварт өвчний хор уршгийг арилгахаар ажилласан Онцгой байдлын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага, Мал эмнэлгийн байгууллага, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага бусад байгууллага /Нутгийн захиргааны байгууллага, иргэд, аж ахуйн нэгж/-аас ажилласан нийт хүч, хэрэгслийн тоог баганын харгалзах нүдэнд бичнэ.

3, 4 дүгээр мөрөнд: голомтын бүсэд ажилласан хүч, хэрэгслийн тоог баганын харгалзах нүдэнд бичнэ.

5, 6 дугаар мөрөнд: сэжигтэй бүсэд ажилласан хүч, хэрэгслийн тоог баганын харгалзах нүдэнд бичнэ.

7, 8 дугаар мөрөнд: хамгаалалтын бүсэд ажилласан хүч, хэрэгслийн баганын харгалзах нүдэнд бичнэ.

9 дүгээр мөрөнд: Өвчингүй бүсэд ажилласан хүч, хэрэгслийн тоог баганын харгалзах нүдэнд бичнэ.

БҮЛЭГ III: ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭ

10. Гоц халдварт өвчний голомтыг устгахад зарцуулсан зардал: Улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс гаргасан зардлыг баганын харгалзах нүдэнд бөглөнө. Зардлын задаргааг сая төгрөгт шилжүүлэн байгууллага тус бүрээр албажуулан хавсаргасан байна.

11. Учирсан хохирол, биетээр

Мал, амьтны гоц халдварт өвчнөөр өвчилсөн, хорогдсон, устгасан мал, амьтны тоог төрөл тус бүрээр баганын харгалзах нүдэнд бичнэ.

12. Хэрэгцээний тойм

Мал, амьтны гоц халдварт өвчин цаашид тархах, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, анхдагч хэрэгцээ хангах, шаардлагатай тохиолдолд хэрэгцээний тойм хүснэгтийг бөглөнө.

1-6 дугаар мөрөнд анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай зүйлсийг баганын харгалзах нүдэнд бичнэ.

7-25 дугаар мөрөнд Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд нэмэлтээр шаардлагатай байгаа хүч, хэрэгслийг төрөл тус бүрийн тоо, зардлыг сая төгрөгт шилжүүлэн баганын харгалзах нүдэнд бичнэ.

БҮЛЭГ IV: ГАМШГИЙН ТҮВШИН, ЗЭРЭГЛЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комисс гамшгийн зэрэглэлийг тогтооно. /ЗГ-ын 2018 оны 327 дугаар тогтоол "Гамшгийн зэрэглэл тогтоох журам"-ын 3.2-т зааснаар/

13. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Тухайн өвчний үзүүлэлтийг үр дүнгээр баганад нөхөж шалгуурыг давсан эсэхийг үнэлнэ.

14. Гамшгийг тодорхойлох

13 дугаар хүснэгтэд үндэслэн гамшиг, аюулт үзэгдлийн аль болохыг дугуйлна.